



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 30 өдөр

Дугаар Б/105

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8, "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн дүрмийн 03 дугаар зүйлийн 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Л.Хандсүрэнг Өмнөдэлгэр сумын "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн даргыг түр орлон гүйцэтгэгчийн ажлаас 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн чөлөөлж, Г.Мөнх-Оргилыг ойн ангийн даргаар томилсугай.

2. Л.Хандсүрэнд холбогдох тооцоог хийж дуусгахыг Өмнөдэлгэр сумын "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн нягтлан бодогч /Л.Сарантуяа/-д даалгасугай.

3. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Б.Дархантөр

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд:

Б.Мөнхжаргал

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэр хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн

Л.Сарантуяа

"Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн нягтлан бодогч

Э.Батсайхан

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой ангийн мэргэжилтэн

4. Ойн ангийн даргыг мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантөр/-д, энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

